

## Багш- мэргэжил, арга зүй


XXI зууны хөгжил дэвшил, мэдээлэл харилцааны эринд багш мэргэжлийн онцлог, багш- олон нийттэй ажиллах арга зүйд анхаарах шаардлага тулгарч байна. Боловсрол судлалын салбарт багшийн хөгжил, багш мэргэжлийн онцлог зэргээр олон чиглэлийн судалгааны бүтээлүүдээс Л.Жамц судлаачийн тодорхойлсон “багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсролын загвар”- ыг бүрэн дунд боловсролын газарзүйн сургалтын хөтөлбөрийн зорилгыг багшийн мэргэжлийн боловсролын загвартай уялдуулан авч үзэж болохоор байна (Зураг 1).



Зураг 1. Багшийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын боловсрол (Жамц Л, 2016)

Багш нь сурагчдад мэдлэг, чадвар эзэмшүүлэхээс гадна, бие хүнийг хөгжүүлж, төлөвшүүлдгээрээ бусад мэргэжлээс ялгаатай. Ийм ч учраас багшийн мэргэжил- дидактикийн ур чадвараас гадна харилцаа, олон нийттэй ажиллах арга зүйн ур ухаан чухал нөлөөтэй.


Конструктивист онолоор бол суралцахуйг нийгмийн, харилцан үйлчлэлтэй үйл явц гэж үзэх нь зүйтэй. Багш нар суралцахын тулд хуучнаасаа илүү хамтарч, харилцан холбоотой ажиллах шаардлагатай (Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антонио,, 2013) гэж багшийн нийгмийн талын харилцааг тодотгож өгсөн байна.



Зураг 2. Когнитивист ба конструктивист хандлагын багшлахуй- суралцахуйн харьцуулалт (Reinfried, 2004)

Блумын таксономийн зорилгуудаас хамгийн их судлагдсан нь когнитив зорилго буюу сурагчдын эзэмших когнитив чадвар юм. Ялангуяа байгалийн ухааны сургалтад когнитив чадварыг тодорхойлдог (Бурмаа Б, Улаанбаатар). Газарзүйн хичээл нь нэг талаасаа байгалийн юмс үзэгдлийн цаг хугацаа- орон зай дахь хувьсал өөрчлөлт, харилцан хамаарлыг судалдаг бол нөгөө талаас хүн- нийгэм- эдийн засгийн шинж чанар, хамаарал, өөрчлөлтийг мөн цаг хугацаа- орон зайн талаас нь, байгаль- нийгмийн харилцан үйлчлэл, үзэгдэл явцыг судалдаг өргөн хүрээний суурь шинжлэх ухаан юм. Иймээс газарзүйн хичээл сургалтад багшлахуй- суралцахуй нь шинжлэх ухааны мөн чанар нь үндсэн зарчим, үнэт зүйл, онолууд, судалгааны олон чиглэл бүхий үйлээр илэрдэг. Эдгээрийг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан төлөвлөх нь багшийн ур ухаан, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, түгээх арга суугаас ихээхэн хамаарна.

Газарзүйн багшлахуй- суралцахуйд нөлөөлөгч гол хүчин зүйлсийн хамаарлыг дараах байдлаар зурагласан (Wudu M, Tefera T, Woldu A, , 2009) байдаг.



Зураг 3. Газарзүйн багшлахуй- суралцахуйн загвар

Багш нь хүүхдэд мэдлэг, чадвар эзэмшүүлж, хандлага төлөвшүүлэхдээ өөрөө давхар сурч, дидактик арга зүй нь хөгжиж байдаг. Багшийн өдөр тутмын үйл ажиллагаандаа тулгарах бэрхшээлийг шийдвэрлэж болохуйц судлаач багшийн зарим аргуудыг дараах байдлаар тодорхойлсон (Отгонцэцэг Д, 2013). Үүнд:

- ✦ Харьцуулалтын арга
- ✦ Хэмжилт
- ✦ Туршилт
- ✦ Хийсвэрлэх арга
- ✦ Ажиглалтын арга
- ✦ Асуулгын арга
- ✦ Нэртэй ба нэргүй судалгаа
- ✦ Нээлттэй ба хаалттай асуулга
- ✦ Ярилцлагын арга
- ✦ Ном зохиол судлах арга

Судлаач багшийн мэдэж, эзэмшсэн байвал зохих дээрх аргуудыг өөрийн сурагчдын оношлох, эцэг эх, асран хамгаалагчтай нь харилцахдаа хэрэглэж дадах нь суралцахуйд чухал нөлөөтэйг анхаараарай.

### Ном зүй

Reinfried, S. (2004). Do curriculum reforms affect classroom teaching in geography? The case study of Switzerland. *International research in geographical and enviromnetal education*, 13, No.3.

Wudu M, Tefera T, Woldu A, . (2009). *The practice of learner- centred methods in Ethiopian*. Jimma University.

Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антонио,. (2013). *Багшлахуйн чанарыг сайжруулахад багшийн хөгжил*. (БСШУЯ, Орч.) Лондон: Springer.

Бурмаа Б. (Улаанбаатар). *Физик дидактик*. 2012: Шинрөпринтс.

Жамц Л. (2016). *Боловсрол судлалын үндэс*. Улаанбаатар: Адмон принт.

Отгонцэцэг Д. (2013). *Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс*. Улаанбаатар: Насан туршийн боловсролын үндэсний төвийн хэвлэх үйлдвэр.